

Батлав . Сургалтын менежер

Нэгж хичээлийн нэр : Цэцэг тарих

Ээлжит хичээлийн нэр: Явцын тайлан

Хугацаа: 60мин

Зорилго: Сурагцагч бүр судалгааны явцыг тайлагнах

Зорилт :

- Мэдээллийн эх сурвалж
- Мэдээллийн товч агуулга
- Асуулт хариулт
- Нэмэлт мэдээлэл

Арга зүй :харилцан яриа,

Зохион байгуулах хэлбэр : Сурагчид баг болон хичээллэнэ.

Хичээлийн үйл явц:

№	Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
	сэдэлжүүлэлт	Самбарт зүрх зурна. -Энэ юу вэ ? -Энэ зураг юуг илэрхийлдэг вэ ? \\үүнийг хараад чи юу гэж бодож байна вэ ?\n -Тоогоор хайрыг яаж илэрхийлж болдог вэ? -хайртай хүмүүстээ юу бэлэглэдэг билээ. Ямар цэцэг бэлэглэх вэ ? Самбарт “Сарнай” цэцэг байрлуулна.	Зурсан зургийг ажиглаад хариулна. -Зүрх,гэлийн хөзөр,бунд...гм -хайр дурлал,ээж аавын хайр, зүрх сэтгэлийн хайр,багшийн хайр, найз нөхдийн хайр... гм 247 Цэцэг,бэлэг,алим,жимс,чихмэл тоглоом ... гм Сарнай,хонхон цэцэг	Хүүхдүүдийн оролцоог ажиглах

	Мэдлэг бүтээх үе	Та нар энэ сарнайг амьд гэж бодоод арчилж, хайрлаж ургуулцгаая. Багш : -мэдээлэл өгөхдөө дүрсээр, зургаар схемээр байж болохыг сануулах. Сурагчид ,багаас асуух зүйл байна уу ? Чиглүүлнэ Дэвтэрт нь тэмдэглүүлэх	Тэгье Багууд гэрийн даалгаварт хийсэн мэдээллийн эх сурвалж, мэдээллээ танилцуулна. Хүүхэд бүр өөрийн санаа бодлоо илэрхийлнэ. Сурагчид сонирхсон зүйлээ асууна. Хариулна Шинээр мэдсэн зүйлээ дэвтэртээ тэмдэглэнэ	Баг бүрт мэдээлэл өгөхөд 3 минут өгнө Санаа давхцахгүй байхыг багш анхааруулах
	Бататгал Дүгнэлт	Багш сурагчдын мэдээллийг цэгцэлж нэгтгэн өгнө. Өөрийн бэлгэсэн нэмэлт мэдээллийг өгнө. Сурагчдад бэлтгэсэн А-5ын хэмжээтэй улаан өнгийн цаасыг тараан өгч цэцэг хийлгэнэ. Та нар өнөөдөр шинээр юу, юу мэдэж авсан бэ ? Цэцэгний тухай дуу, шүлэг мэдэх үү ? Энэ дууг сонсгооё. Алтанзул дууны дахилтыг сонсоно. Энэ дуунаас та нар юу гэж ойлгосон бэ ?	Багштайгаа , бие биетэйгээ харилцан ярилцан мэдээллээ нэгтгэнэ. Сурагчид сонсоно, ажиглана Бичиж тэмдэглэж авна. Багшийн өгсөн зааврын дагуу сарнай цэцэг бүтээнэ. Цэцэг арчилгаа ,нэр төрөл, тарих дараалал, ач холбогдол , бэлгэдлийн тухай мэдсэн Цэцэг хийж сурсан. Өөрсдийн мэддэг дуугаа нэрлэнэ.дуулна. Дууг сонсоно. Дохилтыг дэвтэртээ бичиж авна. Ярилцана Хайрлана, ургуулна, усална, арчлана	Сурагчдыг жигд оролцуулах тал дээр анхаарах Ажиглаж дэмжин тусална. Цэцгийг хайрлах сэтгэл төрүүлэх
	Гэрийн даалгавар			

Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн
дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл

ЦЭЦЭГ ТАРИХ

ээлжит хичээлийн сайжруулсан хөтөлбөр

Хөтөлбөр боловсруулсан:

Булган аймаг Гурванбулаг сум бага ангийн багш Д. Эрдэнэчимэг

Булган аймгийн Сэлэнгэ сум бага ангийн багш Алтантуул

Өвөрхангай аймаг бага ангийн багш

Өвөрхангай аймаг БСГ мэргэжилтэн Жансмаа

Хөвсгөл аймаг бага ангийн багш Наран

Хичээл зохион байгуулсан багш Л.Намуунтуяа

Булган хот

2012 он 11 сар

